



СОЁМБО

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ

МЭЭДЭЭ

№192 /402/

2022.10.26

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

Цаг үе, үйл явдал

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ ДЭЛХИЙН ЖИШИГТ НИЙЦСЭН МЭС ЗАСЛЫН ӨРӨӨТЭЙ БОЛЛОО



БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМ

"СОЁМБО" РЕДАКЦ

Батлан хамгаалахын сайдын багц төсөл, Австри Улсын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлээр хэрэгжиж байгаа "Цэргийн төв эмнэлгийн II" төслийн хүрээнд шинээр суурилагдсан мэс заслын тоног төхөөрөмжтэй орчин үеийн ламинар урсгал бүхий вакум мэс заслын өрөөний нээлттэй намрын адаг сарын шинийн нэгний билэгт сайн өдөр хийж, цесний чулуу түүх дурангийн мэс засал, элэгний хагалгаа,

өвдөгний болон түнхний үе бүрэн солих мэс заслуудыг амжилттай хийлээ. Цэргийн төв эмнэлгийг өндөр хөгжилтэй орнуудын цэргийн эмнэлгийн жишигт хүрсэн Монгол Улсын тэргүүлэх клиникийн эмнэлэг болгон хөгжүүлэхийн тулд дээрх төслийн хүрээнд 61 нэр төрлийн шинэ дэвшилтэт техник, технологийн тоног төхөөрөмжийн шинэчлэл хийж, вакум хагалгааны өрөөнүүд, мэс засал, ариутгалын болон судсан

дотуурх эмчилгээний багаж хэрэгслийг шинэчлэн хүний нөөцийн чадавхаа бэхжүүлсэн байна.

Ламинар урсгал бүхий вакум мэс заслын өрөөний нээлтийг хийж, түнх солих мэс заслыг ЗХЖШ-ын Эрүүл мэндийн хэлтсийн дарга хурандаа Т.Сүхбаатар, Цесний дурангийн мэс заслыг ЦТЭ-ийн Мэс заслын төвийн захирал хурандаа Н.Оюунсамбуу, өвдөгний үе солих мэс заслыг ЦТЭ-ийн Гэмтлийн төвийн

дарга дэд хурандаа Ш.Батсайхан, Элэг тайрах мэс заслыг ЦТЭ-ийн эмч дэд хурандаа А.Ганбат, Бамбай булчирхайн мэс заслыг хүний гавьяат эмч дэд хурандаа доктор Л.Жамбалжав, нар удирдаж амжилттай хийж гүйцэтгэлээ.

Тус эмнэлэгт хагалгааны долоон өрөө ашиглагдаж байгаагаас таван өрөөг вакум болгож төхөөрөмжилжээ. Бүгд Найрамдах Австри Улсын "СТА" брэндийн ламинар урсгал бүхий европын холбооны хагалгааны өрөөний Н6020:2015 стандартыг хангасан вакум өрөөтэй болсноор эмчлүүлэгчийн мэс заслын дараах халдварын эрсдэлийг арилган, эмч сувилагч нарын ажлын байрны эрүүл ахуй, хөдөлмөрийн аюулгүй нөхцөлийг бүрдүүлж, үе солих, эрхтэн шилжүүлэн суулгах хагалгааны өрөөний стандартын шаардлагыг бүрэн хангаж чанарын дэвшилтийг нэвтрүүлсэн байна.

"СТА" брэнд нь нян үрждэггүй, цахилгаангүйжүүлэх материалаар хийгдсэн, тааз, хана, шал, хаалгатай гэдгээрээ давуу талтай. "FLECK" брэндийн

агаарын урсгал, сөрөг даралт үүсгэх бүхий сорох, үлээх агааржуулалтын систем болон бактерийг шүүх HEPA шүүлтүүрээр тоноглогдсон. Өрөөний температур, чийгшлийг +18+25 градус хүртэл автоматаар тохируулах боломжтой. Орчин үеийн шаардлага хангасан гэрэлтүүлэг, цахилгааны монтажтай. Мэдрэгч бүхий автомат 2 хаалга, "Draeger" брэндийн таазанд суурилагдсан "MOVITA" загварын цахилгаан, хийн түгээлтийн аюулгүй байдлыг хангасан шийдэл бүхий мэдээгүйжүүлдгийн систем зэргээс бүрдэж байгаа юм.

Нийслэл хотын есөн дүүрэг, 21 аймаг, 330 сумдаас ард иргэдийг харьяалал харгалзахгүй хүлээн авч амбулаторийн үйлчилгээ үзүүлж, зах зээлийн өртгөөр төлөвлөгөөт мэс заслыг хийх юм байна. Мөн шинээр хавдрын тасгагтай болж байгаа бөгөөд цэргийн алба хаагчид төдийгүй ард иргэдэд яаралтай тусламж үйлчилгээг үзүүлэхийн зэрэгцээ шаардлагатай тохиолдолд хагалаа хийх нөхцөлийг бүрдүүлэн ажиллаж байна.

Х.УНДАРМАА

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀ 4	☁ -9

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀ 35	☁ 23

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD	3.410	3,420
EUR	3,380	3,405
CNY	466	471
RUB	52.50	52.80
JPY	23.10	23.50
KRW	2.40	2.45

ЗУРХАЙ



2022.10.26 /ЛХАГВА ГАРАГ/ БИЛГИЙН ТООЛЛЫН 1

НАМРЫН АДАГ ЦАГААН НОХОЙ САР НЭГ ЦАГААН МЭНГЭТЭЙ ХАР ХУЛШАНА ӨДӨР

ҮС ЗАСУУЛБАЛ:

НАС АХАР БОЛНО

НАРАН УРГАХ, ШИНГЭХ: 07.27-17.45

БАРИЛДЛАГА:

Үхэх

ШҮТЭН БАРИЛДЛАГА:

САНСАР

ЦОГЦОЛБОР ТЭМЦЭЭНИЙ НЭЭЛТИЙН ЁСЛОЛ БОЛЛОО



Энэ сарын 25-ны өдөр ЗХЖШ-ын Жагсаалын талбайд Монгол Улсын Зэвсэгт хүчинд Цэргийн сургалт бэлтгэлийн алба үүсэж хөгжсөний түүхт 100 жилийн ойг угтсан бүтээлч ажлын нээлтэд зориулсан ёслолын ажиллагааг зохион байгууллаа.

Энэхүү ёслолын ажиллагаанд Зэвсэгт хүчний Жанжин штабын орлогч дарга хурандаа Т.Галбадрах, Сургалт бэлтгэлийн газрын дарга бригадын генерал Г.Болор болон Зэвсэгт хүчний Жанжин штаб, төрлийн цэргийн командлалууд, Барилга, инженерийн

цэргийн удирдах газрын удирдлага, нийт бие бүрэлдэхүүн оролцсон юм. Энэ үеэр ЗХЖШ-ын Сургалт бэлтгэлийн газрын дарга бригадын генерал Г.Болор хэлсэн үгэндээ "1922 онд цэргийн бүх ангиуд цэргийн хэрэгт хэрхэн суралцаж байгааг шалган байцааж, заавар зөвлөгөө өгч байх байцаах түшмэлийн орон тоог баталж, 11 дүгээр сарын 20-ны өдөр анхны цэргийн шалган байцаагч түшмэлээр Х.Чойбалсанг томилж дүрэм, журмыг тогтоон, батлан гаргаснаар шинэ цагийн Зэвсэгт хүчний цэргийн сургалт

бэлтгэлийн алба буюу одоогийн ЗХЖШ-ын Сургалт бэлтгэлийн газрын үндэс суурь тавигдсан түүхтэй. Зэвсэгт хүчний шинэчлэлийн бодлогын хүрээнд цэргийн сургалт бэлтгэлийн тогтолцоо, агуулгыг нэгдсэн удирдлагаар хангах, Зэвсэгт хүчний стратеги болон урт, дунд хугацааны төлөвлөлттэй уялдуулах хэрэгцээ, шаардлагын үүднээс ЗХЖШ-ын Сургалтын бодлогын хэлтсийг Батлан хамгаалахын сайдын тушаалаар Сургалт бэлтгэлийн газар болгон өргөжүүлж, чиг үүргийг нь

тодорхойлсон.

Өчигдөр тус газар нь Зэвсэгт хүчний цэргийн сургалт бэлтгэлийн бодлогыг тодорхойлж, сургалтын тогтолцоог боловсронгуй болгох, цэргийн сургалт бэлтгэл, сэтгэл зүйн хангалтыг төлөвлөх, удирдан зохион байгуулах, зохицуулах, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллагын бэлэн байдал, дайчилгааны бэлтгэлийг хангах, орон нутгийн цэрэг, томилгоот нэгжүүдийн болон бүх нийтийг цэргийн хэрэгт сургаж бэлтгэх, иргэн-цэргийн харилцааг бэхжүүлэх, иргэд, хүүхэд, залууст цэрэг-эх оронч үзлийг төлөвшүүлэхэд дэмжлэг үзүүлэх үндсэн чиг үүрэгтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.

2023 оныг "Залуу офицеруудын манлайллын жил" болгон зарласан нь хүний хөгжил, төлөвшлийг сургалт бэлтгэлтэй нягт уялдуулж, хувь хүний ёс зүй, ёс суртахуун, цэрэг-эх оронч үзэл, хүмүүжлийг төлөвшүүлэх ажлыг тасралтгүй зохион байгуулах замаар удирдах бүрэлдэхүүний залгамж халааг бэлтгэхэд оршиж байна." хэмээн онцолсон юм.

Энэхүү нээлтийн цуглааны дараа ЗХЖШ-ын Зохион байгуулалтын бүтцийн нэгж, төрлийн цэргийн командлаад, удирдах газрын бие бүрэлдэхүүний дунд "Олс таталтын тэмцээн"-ий урьдчилсан тоглолт боллоо.

Ойг угтаж зохион

байгуулах олс таталтын болон гар бөмбөгийн тэмцээнийг 10 дугаар сарын 24-ний өдрөөс 11 дүгээр сарын 15-ны өдрийг хүртэлх хугацаанд зөвхөн мягмар гарагуудад үдээс хойш зохион байгуулах ба ажлын ачаалал, эрч хүчийг сулруулахгүйгээр "Нэг өдөр-нэг баг" зарчмаар явагдана. ЗХЖШ-ын Сургалт бэлтгэлийн газрын 100 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээний хүрээнд дараах ажлуудыг хэрэгжүүлэхээр төлөвлөжээ.

Үүнд:

- 1.ЗХЖШ-ын зохион байгуулалтын бүтцийн нэгж, төрлийн цэргийн командлал, удирдах газрын бие бүрэлдэхүүний дунд олс таталт, гар бөмбөгийн тэмцээн;
- 2.ЗХЖШ-ын ахлах мэргэжилтэн, мэргэжилтнүүдтэй "Удирдагчийн манлайлал" сургалт;
- 3."Эрүүл агаар эм" өдөрлөг;
- 4."Зэвсэгт хүчний цэргийн сургалт бэлтгэл-100 жил" сэдэвт эрдэм шинжилгээний бага хурал;
- 5.Монгол цэргийн музейд үзэсгэлэн гаргаж, олон нийтэд сурталчлах;
- 6."Зэвсэгт хүчний тэргүүний заах арга зүйч нэгж, албан тушаалтан"-ыг шалгаруулах;
- 7.Заах арга зүйн талаар нэгтгэл, ангиудын салаа, ротын захирагч, албадын дарга нартай цахим сургалтыг зохион байгуулах;
8. Баярын хурал, хүндэтгэлийн концертыг бэлтгэж тоглуулна.

Хошууч Ц.ПҮРЭВДОРЖ



КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 633,247,821

Эдгэрсэн

Нийт: 612,270,728

Нас барсан

Нийт: 6,584,151

ЭНХИЙГ САХИУЛЖ БУЙ ЦЭРГИЙН АЛБА ХААГЧИЙН АР ГЭРТ ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЛЭЭ



Зэвсэгт хүчний 084 дүгээр анги БНӨСУ-д явагдаж буй НҮБ-ийн мандаттай энхийг дэмжих ажиллагааны Монгол Улсын Зэвсэгт хүчний цэргийн багийн XI ээлжид Зэвсэгт хүчний 084 дүгээр ангиа төлөөлөн Р-140

радиостанцын дарга ахлах ахлагч Д.Ганхуяг үүргээ нэр төртэй гүйцэтгэж байгаа юм. Даян дэлхийн энх тайван амар амгалангийн төлөө үүрэг гүйцэтгэж байгаа шүхэрчин дайчныхаа ар гэр бүлийг дэмжих,

амьдарч буй орчныг сайжруулах зорилгоор ангийн удирдлага, хамт олны санаачлагчаар хүйтэн сэрүүний улирал эхлэхээс өмнө түүний эзэмшил бүхий 32 м/кв хашааг шинэчлэн засварлаж өглөө.

Цэргийн алба хаагчдын гэр бүл, амьдарч буй орчинд эд материал болон сэтгэл зүйн дэмжлэгүүдийг үе шаттайгаар тогтмол зохион байгуулах нь ажиллагааны газар орон болон байнгын байрлалд ажил үүргээ

гүйцэтгэж буй алба хаагчдын гэр бүлийн харилцаанд эергээр нөлөөлж, тэдэнд урам зориг өгч, цаашид ажил албандаа бүтээлчээр ажиллах нөхцөл бололцоог олгох юм.

ХАНДИВ ГАРДУУЛАН ӨГЛӨӨ



Зэвсэгт хүчний 337 дугаар анги

Ангийн ахмад настан Ж.Жаргалсайханыг ангийн удирдлагууд хүлээн авч, хүндэтгэл үзүүлж, эмчилгээнд шаардлагатай мөнгөн хандивыг гардуулан өглөө.

Ж.Жаргалсайхан нь хээрийн полигоны оператороор, түүний нөхөр ахмад н.Осоржамаа нь сөнөөгч онгоцны полигоны даргаар эл ангидаа олон жил үр бүтээлтэй ажиллаж байгаад гавьяаныхаа амралтад гарсан юм.

НОМЫН ӨДӨРЛӨГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА



Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлал 2022-2023 оны шинэ сургуулийн жил эхэлсэнтэй холбогдуулан Цэргийн сургалт, соёл

хүмүүжлийн хэлтсээс “Номтой нөхөрлөө” аяныг өрнүүлж байна.

Энэ хүрээнд Монгол Улсын төв номын сантай хамтран ажиллах гэрээ байгуулж, тус номын сангийн төлөөлөл энэ сарын 25-ны өдөр командлалын бие бүрэлдэхүүнд үйл ажиллагаагаа танилцууллаа.

Энэ үеэр Монгол Улсын Үндэсний номын сангийн Арга зүйч Б.Гантулга номын сангийн үйл ажиллагааныхаа талаар танилцуулсан бол ном зүйч Т.Наранчимэг “Ном унших зөвлөмж”, Дипломатч, судлаач Б.Баясгалан “Монгол бичигт суралцах үндэсний аян:1936-1945 ололт, бэрхшээл, сургамж” сэдэвт сонирхолтой яриа хийлээ.

МОНГОЛ УЛСЫН БАГ ТАМИРЧИД ТҮҮХЭН АМЖИЛТ ҮЗҮҮЛЖЭЭ



дасгалжуулагчтай баг Э.Хишигдэлгэр хүрэл тамирчид цэц мэргэнээ медаль тус тус хүртлээ. Сорин өрсөлдөж түүхэнд нэг төрөлд байгаагаас, өчигдөр 25м-ийн “Center Fire Pistol” төрөлд буудсан Хүч спорт хорооны тамирчин Монголын тамирчид түүхэнд эхний 3 байр эзэлсэн нь гайхамшигтай түүхэн ОУХМ Ц.Мөнхзул алтан үйл явдал боллоо. МУГД медаль, Аврагч спорт Л.Ундралбат, ОУХМ хорооны тамирчин ОУХМ Ц.Мөнхзул, Баярцэцэг, Т.Баярцэцэг мөнгөн SM Э.Хишигдэлгэр медаль, Алдар спорт нартаа халуун баяр хорооны тамирчин CM хүргэе!

СУРГАЛТ

МОНГОЛ БИЧГИЙН ХИЧЭЭЛ №10

ГЭЗЭГ

Гээг бол титэмт Ма үсгийн гол бүрдүүлэгч, ялгах зурлага юм. Бичмэл тигээр, эврийг дөрвөлжиндүү мохоо өнцөг гаргаж доош эргүүлэн, үзүүрийг нарийхан, уран гаргаж бичвэл сайн. Гээг зурлагыг үгийн эхэнд титэмд нь, дунд, адагт шүдэнд нь зайгүй нийлүүлж, залгаж бичдэг. Хүний гээг хөхөл толгойноосоо хөндий, зайтай явж байдаггүй. Түүн лүгээ адил хэмээн сэтгэж, гээгийг ямагт хөндий бичихгүй байвал сайн.

Дармалаар:

Бичмэлээр



Rank	Name	Country	Discipline	Score
1	1946 TSOGBADRAKH Munkhzul	MGL	Precision Rapid	95 95 90 283 585-25x
2	1948 TUMURCHUDUR Bayartsetseg	MGL	Precision Rapid	90 92 95 277 564-14x
3	1934 ENKHBAT Khishigdelger	MGL	Precision Rapid	94 98 94 286 557-10x
4	1081 SAMADOVA Namina	AZE	Precision Rapid	97 95 94 287 553-14x
5	1004 KONINI Manjola	ALB	Precision Rapid	92 95 91 278 552-10x
6	1333 NASSR Radwan Amra Fattouh	EGY	Precision Rapid	89 95 91 275 544- 9x
7	1318 ELKAMSHANY Hadeer Saad Mohamed	EGY	Precision Rapid	90 86 92 268 501-11x
8	1991 JIMOH Almatu	NGR	Precision Rapid	88 90 87 265 484- 3x

Египет улсын Кайр хотод зохион байгуулагдаж буй 53 дахь удаагийн буудлага спортын Дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд Монгол улсаас 15 тамирчин, 2дасгалжуулагчийн бүрэлдэхүүнтэйгээр оролцож байна. Тус ДАШТ-д Монгол улс, Зэвсэгт хүчнээ төлөөлөн БХЯ-ны харьяа, Зэвсэгт хүчний "Алдар" спорт хорооны МУГД дэд хурандаа Л.Ундралбат

